



9. Гудамж талбай, нийтийн
байгууламжийн тогтолцох замжийн
далдаа улчилгээний Барилга

10. Бүх шатны
талбай зөхөн түүрэлжилтийн
хэрэгжилтийн хянажт Г Улсын
Улсын
Онцгой комиссын Ажлын
хариуцлагыг өндөржүүлэх тухай

2021 оны 01 сарын 01 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Халдварт хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 238 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт тус тус ДААЛГАХ НЬ:

1. Дэлхийн улс орнуудад болон Монгол Улсын хэмжээнд коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээг бүх түвшинд чангатгах,

2. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах,

3. Цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэмийг сайжруулах шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

4. Гамшгаас хамгаалах бүх шатны төлөвлөгөөг тодотгон, ажилтан, албан хаагч бүрийг томилгоожуулж, ажил үүргийн хуваарийг баталж, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх,

5. Хот, аймаг, сум хооронд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг сайжруулах, халдвар хамгааллын болон хорио цээрийн дэглэмийг чанд сахиулах арга хэмжээг зохион байгуулах,

6. Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах чиглэлээр мэдээ, мэдээлэл, сээрэмжлүүлэг, ухуулах хуудас зэргийг бэлтгэн нийтийн эзэмшилийн гудамж, талбай, нийтийн тээвэр болон олон нийтийн үйлчилгээний газраар зорчих иргэдэд түгээж, байрлуулан, зарлан мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх,

7. Олон нийтийн газарт иргэд хоорондын зайд барьж зорчих /1.5-2 метр/ тэмдэг, тэмдэглэгээг байршуулж, амны хаалт зүүх, халдвар хамгааллын дэглэм мөрдөж үйлчилгээний шаардаж, заавар, зөвлөмжөөр хангах,

8. Үйлдвэр, үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдыг амны хаалт, нүүрний хамгаалах халхавч, бээлий хэрэглэж иргэдэд үйлчилж хэвшүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахих,

9. Гудамж талбай, нийтийн орон сууц, худалдаа үйлчилгээний барилга байгууламжийг тогтмол халдвартгуйжүүлэх,

10. Бүх шатны аж ахуйн нэгж, байгууллага, нийтийн эзэмшлийн гудамж талбай, зах, худалдаа үйлчилгээний төвүүдэд иргэдийн байршлыг тогтоох зорилгоор QR код үүсгэх нэвтрэх хэсэгт байршуулах ажлыг эрчимжүүлж, хяналт тавих,

11. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлын мэдээ тайланг нэгтгэн Улсын Онцгой комиссын Ажлын албанад 7 хоног бүрийн Баасан гарагт цахимаар болон албан бичгээр ирүүлэх.

ДАРГА

Я.СОДБААТАР

VXA0168